



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 11 сарын 07 өдөр

Дугаар А/380

Хэрлэн сум

Мотоциклоор замын хөдөлгөөнд оролцохыг
түр хугацаагаар хориглох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.6-ын "а", Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.6.1, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хүйтний улирал эхэлж аймгийн хэмжээнд хур тунадас унаж, зорчих хэсэгт хальтиргаа гулгаа үүсэж замын хөдөлгөөнд эролцогчдод хүндрэл бэрхшээл учирч болзошгүй байх тул иргэдийн амь нас, эрүүл мэндийг хамгаалах, учирч болох эрсдлийг багасгах, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах зорилгоор мотоциклоор замын хөдөлгөөнд оролцохыг 2018 оны 11 дүгээр сарын 08-ны өдрөөс 2019 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл түр хугацаагаар хориглосугай.

2. Иргэдэд замын хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай анхааруулга, сэрэмжлүүлэг өгч сурталчлах ажлыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр шуурхай хүргэж зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг сумдын Засаг дарга нарт, аймгийн Цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа /Ж.Болд-/д тус тус үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль, эрх зүйн хэлтсийн дарга /Л.Бат-Октябрь-/д даалгасугай

ЗАСАГ ДАРГА

Н.ГАНБЯМБА